



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2020/26/СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2020 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг: Утас:261668 Цахим хаяг:naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Гүнжидмаа Утас:261885 Цахим хаяг:gunjidmaag@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Сэржмядаг Утас:261885 Цахим хаяг:serjmyadagb@audit.gov.mn</p> <p>Аудитор: А.Даваадорж Утас:261885 Цахим хаяг:davaadorja@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Мөнхчимэг Утас:261885 Цахим хаяг:munkhchimegg@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Дашдаваа Утас:261885 Цахим хаяг:dashdavaach@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудитын тайлан .....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	8
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө .....	8
2.8.2 Авлага.....	9
2.8.3 Урьдчилгаа .....	10
2.8.4 Бараа материал .....	11
2.8.5 Нөөцийн бараа .....	12
2.8.6 Үндсэн хөрөнгө .....	13
2.8.7 Өр төлбөр .....	15
2.8.8 Засгийн газрын хувь оролцоо.....	16
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	16
2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	18
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	20
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	21
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	21
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	21
3. Менежментийн захидал .....	22
3.1 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал .....	22
3.2 Хөрөнгө оруулалтын санхүүжилттэй холбоотой асуудал .....	22
3.3 Харьяа газруудад илэрсэн алдаа, зөрчилтэй холбоотой асуудал .....	23
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	24
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	24
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	25
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	26
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	27
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	28
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	30

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АДОБАЗ	Аймаг дундын отрын бэлчээрийн ашиглалтын захиргаа
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУСУТ	Малын удмын сангийн үндэсний төв
МХС	Мал хамгаалах сан
МЭГ	Мал эмнэлгийн газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
ОХУ	Оросын холбооны улс
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХААБ	Хөдөө аж ахуйн бирж
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХААҮШУОНТ	Хөдөө, аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД Ч.УЛААН ТАНАА

2020.04.24 № 1435  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн холбогдох хууль журмыг мөрдөн ажиллах, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 05-наас 2020 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Ахлах аудитор Б.Сэржмядаг, аудитор А.Даваадорж, Г.Мөнхчимэг, Ч.Дашдаваа нар гүйцэтгэв.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 01/1288 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

## **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь салбарын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх замаар түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэний сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн орлого, бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн салбарын эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнс, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хангасан хувцас, хэрэгслээр хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мал аж ахуй, мал эмнэлэг, газар тариалан, хүнс, хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны тогтвортой хөгжлийг хангах, эрчимжүүлэх, дотоод худалдааны бодлогыг боловсруулах, салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эдийн засаг, төсвийн тооцоо, хөрөнгө оруулалт, урсгал зардлын төсвийн төлөвлөлт, санхүү, төсвийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, төрийн сангийн үйл ажиллагааг эрхлэх, төсвийн ил тод байдлыг хангаж ажиллах;
- Мал, амьтныг гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчний гаралтыг тогтвортой бууруулж, тархалтыг зогсоох, өвчингүй тайван бүсийг баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлэх;
- Малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, нөөцийг тогтоох, төлөв байдлыг үнэлэх, бүртгэх, тэдгээрийг тогтвортой ашиглах, хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилтийг зохицуулах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарц, чанарыг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлж, дэмжин хөгжүүлэх;
- Мал, амьтан, таримал ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, малын тэжээл, түүний нэмэлтийн хорио цээр, экспорт, импортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах;
- Хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, усан хангамжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
- Тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, эрчимжүүлэх, таримал ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх, тариалангийн эдэлбэр газрыг эргэлтэд оруулах, хөрсний үржил шимийг сайжруулах, хамгаалах, ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Байгалийн гэнэтийн аюул, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах;
- Салбарын үйлдвэрлэлд шинэ, дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, нутагшуулах, техникийн шинэчлэлийг хийх;
- Хөнгөн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, ноос, ноолуур, арьс, ширийг гүн боловсруулах, импортыг орлох, экспортын баримжаатай сүлжмэл, нэхмэл, оёмол хувцас, арьс, ширэн бүтээгдэхүүн, хэрэгслийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;

- Хүн амын эрүүл, баталгаат хоол, хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, дотоод худалдааны бодлогыг боловсруулах, зохицуулах;
- Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, ажлын байрыг шинээр бий болгох, үнэ цэний сүлжээ, кластерийг хөгжүүлэх;
- Өндөр технологийн шинэ салбаруудыг хөгжүүлэн мэдлэгт суурилсан эдийн засгийн үндсийг тавих, төр, хувийн хэвшлийн түншлэлийн оновчтой бодлого, зохицуулалтыг бий болгох, хэрэгжүүлэх.

Төсвийн ерөнхийлөн захирагч УСНББОУС, түүнд нийцүүлэн дараах хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж, төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль
- Малын генетик нөөцийн тухай хууль
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Тариалангийн тухай хууль

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-385 дугаар тушаалаар баталсан байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт шинжилгээ, дотоод аудитын газар 2019 онд харьяа 8 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 5 байгууллагад 2,123.3 сая төгрөгийн 35 зөвлөмж, 71.5 сая төгрөгийн акт, албан шаардлага өгсөн байна. Үүнээс зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэхэд 89.5 хувьтай, 34.7 сая төгрөгийн асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн ажилласан байна.

Мөн ХХААХҮЯ-ны харьяа байгууллагуудын өр, авлагыг барагдуулах ажлын төлөвлөгөөг сайдын тушаалаар батлуулан ТШЗ-чид болон харьяа байгууллагуудад 3 албан даалгавар өгч ажилласны үр дүнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

- Олон жил болсон хугацаа хэтэрсэн өвс, тэжээлийн 40,000.0 сая төгрөгийн зээлийн өглөгөөс 26,815.9 сая, Засгийн газрын бондын төлбөр 99,561.0 сая төгрөгийн эргэн



төлөлтөөс 49,103.2 сая, Хөгжлийн банкны зээлийн 24,428.7 сая төгрөгийн эргэн төлөлтөөс 20,561.6 сая, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн /хуучнаар/ улаан буудайн зээлийн төлбөр 21,053.5 сая төгрөгөөс 10,000.0 сая, нийт 106,480.7 сая төгрөгийг улсын төсөв болон Хөгжлийн банканд төлж барагдуулсан;

- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нийт авлагын 60.1 хувийг эзэлж байгаа ЖДҮХС нь 2009-2018 онд олгосон зээлийн авлага 34,394.7 сая төгрөгийг барагдуулж, 562 зээлийн 170.004.7 сая төгрөгийн зээлийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан ба хугацаа хэтэрсэн зээлүүдэд 5,681.4 сая төгрөгийн алданги, 101.0 сая төгрөгийн нэмэгдүүлсэн хүү тооцож, шинээр үндсэн зээлийн авлага 6.199.4 сая төгрөг, 2019 оны зээлийн хүүгийн авлагын зөрүү 611.5 сая төгрөгийг нэмж бүртгэсэн;
- Үндэсний аудитын газрын зөвлөмжийн дагуу ЖДҮХС-гаас олгох зээлийн төсөл хүлээн авах, сонгон шалгаруулах, үнэлэх, зээл олголтыг бүртгэх, зээлийн үндсэн төлбөр, хүү, алданги, хөшүүргийг иж бүрнээр бүртгэх нэгдсэн программ хангамжийг нэвтрүүлж тус тус ажилласан байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгө 815,180.1 сая төгрөгийн 1 хувь буюу 8,151.8 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

## 2.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

### 2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 14,914.2 сая, эцсийн үлдэгдэл 6,419.0 сая төгрөг болж, 8,495.2 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+ Бууралт-
Касст байгаа бэлэн мөнгө	2.2	28.8	26.6
Банканд байгаа бэлэн мөнгө	14,912.0	6,390.2	-8,521.9
Замд яваа мөнгөн хөрөнгө			0.0
Хадгаламж			0.0
<b>Дүн</b>	<b>14,914.2</b>	<b>6,419.0</b>	<b>-8,495.3</b>
Үүнээс, байгууллагын төрлөөр			0.0
Төсөвт байгууллага	10,711.4	1,482.1	-9,229.3

Төсөл/сан	1,927.7	241.2	-1,686.5
Төрийн сан			0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,275.1	4,695.7	2,420.6
<b>Дүн</b>	<b>14,914.2</b>	<b>6,419.0</b>	<b>-8,495.2</b>

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банканд байршиж буй 6,390.0 сая төгрөгөөс гадаад валютаарх үлдэгдэлгүй байна. Үүнээс: 1,702.0 сая төгрөг төсөвт байгууллагын, 4,688.0 сая төгрөг төрийн өмчит аж ахуйн нэгжийн үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудад мөнгөн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ХХААХҮЯ нь харилцах данснаас анхан шатны бүрдэл дутуу баримтаар 3.8 сая төгрөгийн гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан, төсвийн орлогыг батлагдсан төсвөөс 30.3 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн;
- Мал эмнэлгийн ерөнхий газар ОХУ болон Энэтхэг улсаас малын гоц халдварт шүлхий, мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин худалдан авах 4,302.0 мянган ам.долларын гэрээний төлбөрийг хийхдээ валютын ханшийн зөрүүгийн алдагдал 48.4 сая төгрөгийг бүртгээгүй;
- Шатахууны зардлын өвөл зуны хуваарь, норм норматив баримтлаагүй, авто машин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтад хамрагдаагүй, албан тушаалтан авто машин ашигласан, зардлын ангилал хооронд шилжүүлэн зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан нийт 72.4 сая төгрөг; /Архангай ХХААГ, Говь-Алтай ХХААГ, Баянхонгор ХХААГ 4.8 сая, Дорнод ХХААГ 5.6 сая, Төв аймаг ХХААГ 62.0 сая/
- Төв аймгийн МЭГ нь малчдаас авсан вакцины 13.5 сая төгрөгийг хувийн дансанд төвлөрүүлсэн;
- Томилолтын зардлыг илүү, дутуу тооцсон, анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу, зардлын ангилал буруу гаргасан нийт 9.9 сая төгрөг. /Дорноговь ХХААГ 0.1 сая, Орхон ХХААГ 0.2 сая, Дорнод ХХААГ 2.4 сая, Сэлэнгэ ХХААГ 2.6 сая, Бага оврын трактор төсөл 3.8 сая, Сүхбаатар МЭГ 0.8 сая төгрөг/
- Албан хаагчдын цалин, амралтын мөнгө, урамшууллыг илүү тооцож олгосон, цалингаас НДШ, ХХОАТ суутгаагүй, Төрийн албан хаагчийн мэргэшлийн сонгон шалгаруулалтад оролцоогүй ажилтныг цалинжуулсан, албан томилолтоор ажиллаж байх хугацаанд хоол унааны хөнгөлөлтийг давхардуулан олгосон нийт 20.6 сая төгрөг. /Говь-Алтай ХХААГ 6.6 сая, Архангай ХХААГ 0.6 сая, Баянхонгор ХХААГ 0.6 сая, Сүхбаатар ХХААГ 0.6 сая, Хөвд ХХААГ 0.6 сая, Биокомбинат ТӨҮГ 2.6 сая, ЖДҮХС 5.7 сая төгрөг,

## 2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 543,002.6 сая, эцсийн үлдэгдэл 519,389.6 сая төгрөг болж, 23,613.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/ Бууралт-
Ажиллагчидтай холбогдсон авлага	22.2	55.3	33.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	136,824.7	121,898.2	(14,926.5)
Татаас, санхүүжилтийн авлага	5,496.9	5,778.2	281.3
Зээлийн хүүгийн авлага	-	-	-
Дансны авлага /ТӨҮГ/	1,089.2	1,347.1	257.9
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	67.0	24.6	(42.4)
Бусад авлага	316,051.8	25,442.1	(290,609.6)
Байгууллагаас авах авлага	315,729.4	24,971.1	(290,758.3)
Хувь хүмүүсээс авах авлага	322.4	471.1	148.7
Зээлийн авлага	83,450.8	364,844.0	281,393.2
<b>Дүн</b>	<b>543,002.6</b>	<b>519,389.6</b>	<b>(23,613.0)</b>

Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	447,281.3	408,193.5	(39,087.8)
Төсөл/сан	94,559.0	109,817.2	15,258.2
Төрийн сан			-
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,162.3	1,378.9	216.6
<b>Дүн</b>	<b>543,002.6</b>	<b>519,389.6</b>	<b>(23,613.0)</b>

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 60.0 хувийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, 38.2 хувийг Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн авлага эзэлж байна.

ЖДҮХС-ийн 310,925.0 сая, төсөл хөтөлбөрийн 53,918.9 сая, нийт 364,844.0 сая төгрөгийн зээлийн авлага, ТЭДС-ийн 115,094.9 сая төгрөгийн иргэд, аж ахуйн нэгжид олгосон дэмжлэг болон техникийн зээлийн байгууллагаас авах авлагын тус тус үлдэгдэлтэй байна. Үүнээс:

- ЖДҮХС-ийн арилжааны банкаар дамжуулан олгосон зээлийн авлага 76,683.6 сая, сангаас шууд олгосон зээлийн авлага 193,250.3 сая, зээлийн хүү 2,749.5 сая, алданги 5,726.1 сая, МХС-гаас шилжиж ирсэн авлага 32,515.5 сая;
- Бага оврын трактор төслийн техникийн зээлийн авлага 50,123.1 сая, КР-1 төслийн 1,523.6 сая, КР-2 төслийн 2,262.3 сая төгрөг;
- ТЭДС-ийн тариаланчдад олгосон дэмжлэгийн авлага 58,681.6 сая, ОХУ-ын техникийн зээлийн авлага 25,399.1 сая, Техник дундын үйлчилгээний төвийн авлага 2,772.5 сая, гурилын үйлдвэрүүдээс авах авлага 19,394.0 сая, жимсний төсөл, суулгац, плантаци, кластерийн зээлийн авлага 8,847.7 сая төгрөг тус тус эзэлж байна.

Авлагын үлдэгдэлд олон жил болсон, хугацаа хэтэрсэн 231,895.7 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- ЖДҮХС-ийн Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 44,568.8 сая, Үндэсний хөрөнгө оруулалтын банкнаас авах 217.8 сая, сангаас олгосон зээлийн авлага 28,209.8 сая;
- МХС-аас шилжиж ирсэн авлага 25,978.6 сая;
- Тариаланчдад олгосон дэмжлэгийн авлага 58,681.6 сая,
- ОХУ-ын техникийн зээлийн авлага 19,448.6 сая, Техник дундын үйлчилгээний төвийн авлага 2,772.5 сая;
- Гурилын үйлдвэрээс авах авлага 18,458.1 сая;
- Жимсний төсөл, суулгац, плантаци, кластерийн 6,941.8 сая;
- БНХАУ-ын төслийн техникийн зээлийн авлага 26,618.1 сая төгрөг тус тус байна

Эдгээр нь олон жилийн насжилттай хугацаа хэтэрсэн найдваргүй авлага нэмэгдэх, дамжуулан зээлийн өр төлбөрөө барагдуулах төлбөрийн чадваргүй болох, ханшийн зөрүүгийн алдагдал хүлээх эрсдэлтэй байна.

*Аудитын илрүүлэлт: Харьяа газруудад авлагын данстай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:*

*Тайлант онд авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй, авлага барагдуулаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй, анхан шатны баримт дутуу нийт 570.4 сая төгрөг. /ХХААХҮЯ 0.2 сая, Дорноговь ХХААГ 4.9 сая, Хөвд ХХААГ 19.1 сая, Хөвсгөл ХХААГ 17.7 сая, Малын удмын сангийн үндэсний төв 28.9 сая, Баянхонгор ХХААГ 11.6 сая, Төв аймаг ХХААГ 4.5 сая, ЖДҮХС 232.9 сая, УМЭАЦТЛ 3.9 сая, ТЭДС 195.0 сая, ТЭДС Хархорин салбар 51.6 сая төгрөг/*

### 2.8.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 2,098.8 сая, эцсийн үлдэгдэл 2,143.4 сая төгрөг болж, 44.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/ Бууралт-
Урьдчилж гарсан зардал	2,076.8	2,143.4	66.6
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	21.1	0.0	-21.1
Томилолтын урьдчилгаа	0.9	0.0	-0.9
<b>Дүн</b>	<b>2,098.8</b>	<b>2,143.4</b>	<b>44.6</b>
Үүнээс, байгууллагын төрлөөр			0
Төсөвт байгууллага	2,035.8	1,824.8	-211.0
Төсөл/сан			-
Төрийн сан			-
ТӨҮГ болон ОНӨҮГ	63.0	318.6	255.6
<b>Дүн</b>	<b>2,098.8</b>	<b>2,143.4</b>	<b>44.6</b>

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд тайлант онд үүссэн 1,919.0 сая төгрөгийн бараа ажил, үйлчилгээний төлбөрүүд байна. Үүнд:

- УМЭАЦТЛ-ийн өргөтгөлийн барилгын 2012 оноос хойш үүссэн ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 1,075.1 сая төгрөгөөр дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй хөрөнгө оруулалтын ажлын үлдэгдэл санхүүжилт 174.8 сая;
- Хүнсний үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний батлагдсан төсвийн үлдэгдлээс оны эцэст нөөцийн мах бэлтгэсэн аж, ахуйн нэгж байгууллагын зээлийн хүүгийн хөнгөлөлтийн төлбөрт урьдчилж шилжүүлсэн Худалдаа хөгжлийн банканд 969.8 сая, Голомт банканд 169.7 сая, ХААН банканд 272.5 сая, нийт 1,412.0 сая;
- Хөдөө, аж ахуйн бирж ХХК-ийн Блокчайн арилжааны программын урьдчилгаа 285.0 сая, бусад бараа ажил үйлчилгээний төлбөрт 25.7 сая;
- Бусад байгууллагуудын бараа, ажил үйлчилгээний төлбөр 21.5 сая төгрөг тус тус байна.

Аудитын илрүүлэлт: Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланд урьдчилгаа данстай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ховд аймагт Малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламжийн лагийн байгууламжийн барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлэхээр 2010 онд 224.2 сая төгрөгийг шилжүүлж урьдчилгаа дансанд бүртгэсэн боловч барилга баригдаагүй байна. Уг асуудлыг “Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

## 2.8.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 44,450.9 сая, эцсийн үлдэгдэл 37,938.1 сая төгрөг болж, 6,512.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/ Бууралт-
Түүхий эд материал	15,584.7	16,766.5	1,181.8
Дуусаагүй үйлдвэрлэл	5.8	-	(5.8)
Бэлэн бүтээгдэхүүн	15,176.3	8,528.2	(6,648.1)
Хангамжийн материал	7,645.3	9,213.9	1,568.6
Мал амьтад	6,038.8	3,429.5	(2,609.3)
<b>Дүн</b>	<b>44,450.9</b>	<b>37,938.1</b>	<b>(6,512.8)</b>
Үүнээс, байгууллагын төрлөөр			-

Төсөвт байгууллага	39,248.4	35,585.2	(3,663.2)
Төсөл/сан	2,394.5	52.4	(2,342.2)
Төрийн сан			-
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,808.0	2,300.5	(507.5)
<b>Дүн</b>	<b>44,450.9</b>	<b>37,938.1</b>	<b>(6,512.8)</b>

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаанд Засгийн газрын 2018 оны 168 дугаар тогтоол, ХХААХҮС-ын 2019 оны А-209 дугаар тушаалаар аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй нийт 4,085.2 сая төгрөгийн бараа материалыг Мал эмнэлгийн газруудад балансаас балансад шилжүүлсэн байна.

Мөн Засгийн газрын 2019 оны 179 дугаар тогтоол, ХХААХҮС-ын 2019 оны А-242 дугаар тушаалаар Мал хамгаалах санг татан буулгаснаар үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 8,769.5 сая төгрөгийн бараа материалыг ХХААХҮЯ, ЖДҮХС, МУСҮТ, зарим аймгийн Хөдөө аж ахуйн газрын эргэлтийн хөрөнгөд тус тус балансаас балансад шилжүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 6,722.3 сая төгрөгийн газар тариалангийн бүсэд барьсан хөрсний үржил шимийг хамгаалах зориулалтай хашаа, жижиг дунд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж тусгай зориулалтын материал дансанд бүртгэлтэй байна. Үүнээс 2018 онд худалдан авсан ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 564.1 сая төгрөгийн хөрөнгө байна.

Аудитын илрүүлэлт: Харьяа газруудад бараа материалтай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Бараа материалын дансны ангилал буруу бүртгэсэн, тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, худалдан авсан бараа материалын орлогыг хүлээн зөвшөөрөөгүй, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, шууд зарлагадсан нийт 130.8 сая төгрөг /Дорноговь ХХААГ, Сүхбаатар ХХААГ, Хөдөө аж ахуйн бирж, Нийслэлийн МЭГ 17.0 сая, Архангай МЭГ 1.1 сая, Баянхонгор ХХААГ 20.9 сая, Дорнод ХХААГ 16.1 сая, Говь-Алтай ХХААГ 50.8 сая, Дорнод МЭГ 24.9 сая төгрөг/
- Архангай ХХААГ 1.9 сая төгрөгийн шатахуун нөөцөлсөн байна.

## 2.8.5 Нөөцийн бараа

Нөөцийн барааны эхний үлдэгдэл 43,883.3 сая, эцсийн үлдэгдэл 74,896.9 сая төгрөг болж, 31,013.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 5 Нөөцийн барааны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/ Бууралт-
Барааны нөөц	-	322.8	322.8
Үрийн нөөц	3,931.3	3,550.5	-380.8
Тэжээлийн нөөц	-	-	0.0
Шатахууны нөөц	16.1	14.6	-1.5
Буудайн нөөц	29,284.0	12,766.8	-16,517.2
Бусад нөөц	10,651.9	58,242.2	47,590.3
<b>Дүн</b>	<b>43,883.3</b>	<b>74,896.9</b>	<b>31,013.6</b>
Үүнээс, байгууллагын төрлөөр			0.0
Төсөвт байгууллага	43,883.3	22,789.8	-21,093.5
Төсөл/сан		52,107.1	52,107.1
Төрийн сан			0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ			0.0
<b>Дүн</b>	<b>43,883.3</b>	<b>74,896.9</b>	<b>31,013.6</b>

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТЭДС-ийн үрийн болон хүнсний буудай дараах үлдэгдэлтэй байна. Үүнд:

- Үрийн буудайн нөөц өмнөх онд 3,931.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байснаас намрын ургацаар 11 аж ахуй нэгжээс 3,355.6 сая төгрөгийн буудайг худалдан авч 142 аж ахуй нэгж иргэдэд 3,736.4 сая төгрөгийн буудайг урьдчилгаа төлбөртэйгөөр гэрээний дагуу олгож, 3,550.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй,
- Хүнсний буудай өмнөх онд 29,284.01 сая төгрөгийн үлдэгдэлтэй байснаас тайлант онд аж ахуй нэгж, иргэдээс 12,249.69 сая төгрөгийн буудайг худалдан авч гурилын үйлдвэрүүдэд 28,766.9 сая төгрөгийн буудайг гэрээний дагуу олгон 12,766.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Дамжуулан зээлийн гэрээгээр иргэд, аж ахуйн нэгжид олгодог техникүүд бусад нөөцөд бүртгэлтэй байна. Үүнд:

- Бага оврын тракторын төслийн техник оны эхэнд 2,342.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байснаас төслийн 3 дугаар үе шатны дамжуулан зээлийн гэрээгээр ХХААХҮС-ын 2019 оны А-139, А-176, А-107 дугаар тушаалаар 65,114.2 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмж хүлээн авч тайлант онд 15,349.1 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг гэрээний дагуу худалдан борлуулж нийт 52,107.2 сая;
- ОХУ-ын техник, тоног төхөөрөмж дамжуулан түрээслэх гэрээний техникийн үлдэгдэл оны эхэнд 10,651.9 сая төгрөгийн байснаас ХХААХҮС-ын 2019 оны А-288 дугаар тушаалаар 8,854.0 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмж гэрээний дагуу хүлээн авч 13,370.9 сая төгрөгийн техник урьдчилгаа төлбөртэйгөөр зээлээр олгож 6,135.0 сая төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна.

*Аудитын илрүүлэлт: ТЭДС нөөцийн бараанд тооцсон хэвийн хорогдол болон хэрэглээний шаардлага хангахгүй болсон нийт 17.1 сая төгрөгийн бараа материалыг байгууллагын даргын шийдвэргүйгээр данснаас хассан байна.*

## 2.8.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 216,399.1 сая, эцсийн үлдэгдэл 227,608.2 сая төгрөг болж, 11,209.1 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/Бууралт-
<b>Биет хөрөнгө</b>	<b>181,676.7</b>	<b>193,107.8</b>	<b>11,431.1</b>
Барилга, байгууламж, орон сууц	108,717.5	109,701.1	983.6
Авто-тээврийн хэрэгсэл	13,901.8	14,571.8	670.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	34,496.7	37,341.8	2,845.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	4,314.5	4,601.6	287.1
Зам, гүүрийн байгууламж	3,534.0	3,534.0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	9,618.4	12,198.7	2,580.3
Дуусаагүй барилга, байгууламж	7,093.8	11,158.8	4,065.0
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>34,722.4</b>	<b>34,500.4</b>	<b>-222.0</b>
Программ хангамж	1,973.2	1,819.3	-153.9
Бусад биет бус хөрөнгө	32,749.2	32,681.1	-68.1
<b>Дүн</b>	<b>216,399.1</b>	<b>227,608.2</b>	<b>11,209.1</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	197,294.5	207,525.1	10,230.6
Төсөл/сан	4.7	4.7	-
Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ	19,099.9	20,078.4	978.5
<b>Дүн</b>	<b>216,399.1</b>	<b>227,608.2</b>	<b>11,209.1</b>

*Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд Засгийн газрын 2018 оны 168 дугаар, ТӨБЗГ-ын 2019 оны 513 дугаар тогтоол болон А-1/4247 тоот зөвшөөрлөөр аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газар 16,265.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Мал эмнэлгийн газруудад балансаас балансад шилжүүлсэн.

Мөн Засгийн газрын 2019 оны 179 дүгээр, ТӨБЗГ-ын 2019 оны 280 дугаар тогтоолоор Мал хамгаалах сангийн 1,143.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ХХААХҮЯ, ЖДҮХС, МЭЕГ, МУСҮТ-д тус тус балансаас балансад шилжүүлсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсөвт байгууллагууд нь 2019 онд урсгал санхүүжилтээр 2,039.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, ТӨБЗГ-ын холбогдох тогтоолын дагуу 814.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталан байна.

Мөн ТӨБЗГ-ын тогтоолоор төсөвт байгууллагууд хооронд 1,810.1 сая төгрөгийн, БСШУСС-ын багцад 585.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэн өгсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,350.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж шинээр худалдан авч, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 875.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авсан байна.

Дуусаагүй барилга дансанд 11,158.8 сая төгрөгийн дараах хөрөнгүүд бүртгэлтэй байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланд төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж байгаа 6,074.9 сая;
- УМЭАЦТЛ-ийн өргөтгөл 1,075.1 сая,
- Алтан дорнод монгол ХХК-ийн татварын өрөнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны үнэлгээ хийлгэсэн хөрөнгийг ТӨХ-ны /хуучнаар/ 2013 оны 555 дугаар тогтоолоор ТЭДС-ийн баланст шилжүүлэн бүртгэсэн 3,014.9 сая;
- ТЭДС-ийн Сэлэнгэ салбарын “Буудай хадгалах хэвтээ агуулах” 470.6 сая;
- ХААБ-ийн Логистикийн төвийн барилга байгууламж 332.5 сая;
- МУСҮТ-ийн цогцолборын орон сууцны шугам сүлжээ 30.2 сая;
- Хэнтий аймгийн ХХААГ-ын барилгын суурь 30.0 сая төгрөг;
- Биокомбинат ТӨҮГ-ын вирус-2 цехийн өргөтгөл 130.6 сая төгрөг тус тус бүртгэлтэй байна.

Үүнээс ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 2012 оноос хойш үүссэн 1,075.1 сая төгрөгийн УМЭАЦТЛ-ийн өргөтгөлийн барилга улсын комисс хүлээж аваагүйгээс дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй байна.

*Аудитын илрүүлэлт: Харьяа газруудад үндсэн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд байна. Үүнд:*

- ХХААХҮЯ нь үндсэн хөрөнгөд бүртгэлтэй орон сууцны барилгын газрыг үнэлж бүртгээгүй;
- Малын удмын сангийн үндэсний төвд 25 нэр төрлийн 47 ширхэг 189.5 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан;
- ЖДҮХС төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зөрчиж "Төсөл сонгон шалгаруулах зээлийн нэгдсэн ERP систем" санхүүгийн программыг 200.0 сая төгрөгөөр худалдан авсан;
- Хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлаагүй, дахин үнэлж бүртгээгүй, өөр зардлын ангиллаас болон эрх бүхий байгууллагын шийдвэргүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн, зардлын ангилал буруу бүртгэсэн, элэгдлийн зардлыг илүү, дутуу тооцоолсон нийт 259.5 сая төгрөг. /Говьсүмбэр ХХААГ, Баянхонгор ХХААГ 0.6 сая, Говьсүмбэр МЭГ 133.5 сая, Булган МЭГ 20.8 сая, Дорноговь МЭГ 31.4 сая, Хэнтий МЭГ 4.6 сая, ХААҮШУОНТ 9.3 сая, Дорнод ХХААГ 22.8 сая, Нийслэлийн МЭГ 36.5 сая төгрөг/ байна.

## 2.8.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 390,368.4 сая, эцсийн үлдэгдэл 329,966.6 сая төгрөг болж, 60,401.8 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №.7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/ Бууралт-
<b>Богино хугацаат өр төлбөр:</b>	<b>161,479.8</b>	<b>105,730.5</b>	<b>(56,210.5)</b>
Богино хугацаат зээлийн өглөг	432.7	13,753.2	13,320.5
Өглөг	161,047.1	95,516.1	(69,531.0)
Ажилчидтай холбогдсон өглөг	55.8	28.7	(27.1)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	21,922.0	7.9	(21,914.1)
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	3,653.9	-	(3,653.9)
Зээлийн хүүгийн өглөг	383.9	384.1	0.2
Бусад өглөг	135,031.5	91,095.4	(43,936.1)
Урьдчилж орсон орлого	4,348.5	461.2	(3,887.3)
<b>Урт хугацаат өр төлбөр:</b>	<b>224,540.1</b>	<b>224,236.1</b>	<b>(304.0)</b>
Урт хугацаат үнэт цаас	99,561.0	50,047.8	(49,513.2)
Урт хугацаат зээл	124,979.1	174,188.3	49,209.2
<b>Дүн</b>	<b>390,368.4</b>	<b>329,966.6</b>	<b>(60,401.8)</b>
Үүнээс, байгууллагын төрлөөр			-
Төсөвт байгууллага	287,184.9	157,074.6	(130,110.3)
Төсөл/сан	103,024.0	172,484.5	69,460.5
Төрийн сан			-
ТӨҮГ болон ОНӨҮГ	159.5	407.5	248.0
<b>Дүн</b>	<b>390,368.4</b>	<b>329,966.6</b>	<b>(60,401.8)</b>

*Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн 105,730.5 сая төгрөгийн үлдэгдлээс 92,905.8 сая төгрөгийн харьяа газруудын дараах өр төлбөр байна. Үүнд:

- ЖДҮХС-д МХС-аас шилжиж ирсэн өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхээр авсан улсын төсвийн зээлийн үлдэгдэл 13,184.0 сая;
- ЖДҮХС-ийн Засгийн газрын бондын өглөгийн алданги 383.8 сая, урьдчилж орсон орлого 30.3 сая;
- ТЭДС нь Бага оврын трактор техникийн төслийн мөнгөн хөрөнгийг зарцуулснаас үүссэн 20,324.5 сая,
- Бага оврын трактор техникийн болон дэмжлэгийн зээлийн эргэн төлөлтийн эзэн тодорхойгүй өглөг 538.3 сая
- ТЭДС-ийн ОХУ-ын техникийн лизингийн Ди Би Эм лизинг ХХК-д өгөх дамжуулан зээлийн өглөг 39,223.8 сая;
- ТЭДС-ийн Монгол Улсыг хөгжүүлэх сангийн үлдэгдэл 11,053.5 сая, Ник ХХК-д өгөх шатахууны дэмжлэгийн өглөг 5,228.9 сая;
- Тариаланчаас стратегийн нөөц бүрдүүлэлтээр худалдан авсан үр, хүнсний буудайн өглөг 2,773.0 сая;
- Халх гол ҮБББЗ-ны газрын маргаантай байгаа аж ахуйн нэгжүүдийн газрын төлбөрийн өглөг 165.7 сая төгрөг тус тус байна.

Урт хугацаат өр төлбөрийн 224,236.1 сая төгрөгийн дамжуулан зээл болон бондын үлдэгдэлд харьяа газруудын дараах өр төлбөр байна. Үүнд:

- ЖДҮХС-ийн Засгийн газрын бондын үндсэн төлбөр 50,047.8 сая, 2014 онд үүссэн Хөгжлийн банкны бондын төлбөр 3,867.1 сая нийт 54,360.2 сая;
- БНХАУ-ын Бага оврын трактор төслийн хөнгөлөлттэй зээлээр тайлант онд 24.5 сая ам.доллар буюу 65,114.2 сая төгрөгийн техникийн зээл нэмэгдэж дамжуулан зээлийн өрийн үлдэгдэл 169,875.9 сая төгрөг тус тус байна.



Урт хугацаат зээлийн 142,459.4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн өр төлбөр байна. Үүнд:

- ЖДҮХС-ийн Засгийн газрын бондын өр төлбөр 50,047.8 сая төгрөгийн үлдэгдлээс 36,047.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн өр төлбөр нь татан буугдсан Капитал банкны эрх хүлээн авагчаас авах авлага, Хөгжлийн банкны бондын 2014 онд үүссэн 3,867.1 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлээс татан буугдсан Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 3,506.0 сая, Үндэсний хөрөнгө оруулалтын банкнаас авах 217.8 сая, нийт 3,723.8 сая төгрөгийн авлагууд тус тус төлөгдөөгүйгээс шалтгаалж нийт 39,723.8 сая,
- БНХАУ-ын Бага оврын трактор төслийн техникийн хөнгөлөлттэй зээлийн 169,875.9 сая төгрөгийн дамжуулан зээлийн үлдэгдлээс 102,905.6 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл тус тус байна.

### 2.8.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 142,016.0 сая, эцсийн үлдэгдэл 140,329.3 сая төгрөг болж, 1,686.7 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 8 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/ Бууралт-
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	128,277.1	127,824.2	(452.9)
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	13,707.0	12,473.1	1,233.8
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	32.0	32.0	0.0
<b>Дүн</b>	<b>142,016.0</b>	<b>140,329.3</b>	<b>(1,686.7)</b>

*Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга 7,712.6 сая төгрөг нь дараах шалтгаанаар үүссэн байна. Үүнд:

- ТЭДС нь өмнөх онуудын авлагын зөрүү болон бараа материал хөнгөлөлттэй үнээр борлуулснаас үүссэн зөрүү нийт 1,609.5 сая,
- ХХААХҮЯ-ны автомашины гараашийг аудитын зөвлөмжийн дагуу тайлант онд дахин үнэлж 704.5 сая,
- 2 төслийн нэгжийн санхүүгийн тайланг Сангийн сайдын багцын санхүүгийн тайланд шилжүүлснээс хуримтлагдсан үр дүн 7,084.3 сая төгрөгийг өмнөх үеийн үр дүнд хааснаас тус тус шалтгаалсан байна.

### 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан урсгал зардалд 133,840.5 сая төгрөг, хөрөнгийн зардалд 42,333.0 сая төгрөг, тусгай сангууд ААН, иргэдэд олгох зээлд зарцуулахаар 70,500.0 сая төгрөгийг тус тус батлагджээ.

Нийт зардлын 204,109.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 42,563.6 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр, улсын төсөв болон сангуудын зээлээс эргэж төлөгдөх төлбөрийг 142,257.7 сая төгрөгөөр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 197,491.7 сая, тусгай сангууд үйл ажиллагааны орлогоос ААН, иргэдэд 61,018.6 төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 29,118.6 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 212.9 сая төгрөгөөр давсан байна. Туслах үйл ажиллагааны орлого 3,186.8 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 10,045.3 сая төгрөгөөр тасарсан нь Тариалан эрхлэлтийг дэмжих сан тариалан эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжид олгосон хор, бордоо, шатахуун, ургамал

хамгааллын бодисын урьдчилгаа төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүйгээс шалтгаалжээ.

Төсвийн нийт урсгал болон хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл 91.8 хувьтай буюу 161,891.6 сая төгрөг, 14,281.8 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Мөн бондын төлбөр болон дамжуулан зээлийн эргэн төлөлтөд улсын төсөвт өмнөх онд 26,815.9 сая төгрөг, тайлант онд 55,666.3 сая төгрөгийг төвлөрүүлж, суутган тооцоогоор 14,236.3 сая төгрөгийг тус тус барагдуулсан байна.

Батлагдсан төсвөөс эдийн засгийн ангиллаар материаллаг дүнтэй дутуу зарцуулсан дараах зардлууд байна. Үүнд:

- Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасны зардлаас арьс шир, ноос, улаан буудайн хувийн хэвшилд олгох татаас шилжүүлгийг гүйцэтгэлээр санхүүжүүлснээс 7,587.4 сая төгрөгийг хэмнэсэн;
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас малчин, мал бүхий этгээдүүдийн нийлүүлсэн сүүнд урамшуулал олгохоор 4,000.0 сая төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэл гараагүй нь ЗГ-аас холбогдох журам батлаагүйгээс шалтгаалжээ.

Хөрөнгө оруулалтын 38 төсөл, арга хэмжээнд 42,333.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 40,163.7 сая төгрөгийн санхүүжилт олгожээ. Олгосон санхүүжилтээс барилга байгууламж, тоног төхөөрөмж 28,280.2 сая, үрийн улаан буудайн стратегийн нөөц бүрдүүлэхэд 11,883.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Ажил гүйцэтгэгч байгууллагад гүйцэтгэлээр 9,513.1 сая төгрөгийн санхүүжилт олгож, 17,756.3 сая төгрөгийг орон нутагт эрхийг шилжүүлж, 100.1 сая төгрөгийг суутган барьцаа дансанд, 192.2 сая төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

Тайлант онд төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс 6,074.9 сая төгрөгийн лаборатори, цэвэрлэх байгууламж, ногооны зоорь, ахуй үйлчилгээний болон жижиг, дунд үйлдвэрийн барилгын төсөв он дамжин тусгагдсанаас шалтгаалан дуусаагүй, 6,722.3 сая төгрөгийн хөрсний үржил шимийг хамгаалах газар тариалангийн хашаа, жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмж ашиглагч байгууллагад шилжүүлээгүйгээс дуусаагүй барилга байгууламж болон тусгай зориулалтын материалын дансанд бүртгэлтэй байна.

Мөн хийгдээгүй 8 ажлын 718.4 сая төгрөгийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

**Нэмэлт төсөв:** Нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлангаар хандив тусламжаар 1,630.5 ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөр 5,453.3 сая, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хөтөлбөр арга хэмжээнээс хуваарилсан хөрөнгөөр 14,423.4 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,700.3 сая, давсан орлогоос 580.0 сая, нийт 23,787.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж бараа ажил үйлчилгээний зардалд 23,632.0 сая, хөрөнгийн зардалд 50.0 сая, нийт 23,682.0 сая төгрөгийг зарцуулж зарцуулаагүй 2,120.6 сая төгрөгийг оны эцэст татан төвлөрүүлж 1,526.1 сая төгрөгийг буцаан авахаар авлагаар тусгаж, 185.9 сая төгрөгийг улсын төсвийн орлогод тооцуулсан байна.

Хандив тусламжаар 1,630.5 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Үүнд:

- Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон алт малын эрүүл мэндийн төсөлтэй хамтын ажиллагааны газартай хамтран Мал эмнэлгийн ерөнхий газар 638.0 сая,
- Говийн Оюу хүлэмж дэмжих сангаас Өмнөговь аймгийн ХХААГ 96.7 сая,
- ХААҮШУОНТ Швейцарын хөгжлийн агентлагаас 134.5 сая,
- Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа Швейцарын хөгжлийн агентлагаас 144.9 сая,

- ХХААХҮЯ Азийн хүнс, хөдөө аж ахуйн санаачилга байгууллагаас 219.6 сая, 2018 онд Засгийн газрын тогтоолоор Оюу толгой ХХК, Эрдэнэс Монгол ХХК, Эрдэнэс таван толгой ХХК-уудын төвлөрүүлсэн 117.0 сая,
- УМЭАЦТЛ зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Солонгос word их сургууль, Английн пирбрайтын хүрээлэнгээс нийт 272.0 сая төгрөг байна.

Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгөөс 5,453.3 сая төгрөг санхүүжилт авсан байна. Үүнд:

- Засгийн газрын нөөц сангаас ХХААХҮЯ-нд “Улсын аварга малчин, улсын хошой аварга малчин” шалгаруулахад 239.0 сая төгрөг
- ЗДНХ-өөс Говь-Алтай, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Сэлэнгэ аймгийн ХХААГ, МЭГ-уудад нийт 5,214.3 сая төгрөг байна.

## **2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 67 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс итгэл үзүүлсэн 6 байгууллага, 4 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан, 57 байгууллага аудитад хамрагдсан байна.

Аудитаар 53 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 4 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 35,556.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 29,537.5 сая төгрөгийн 34 алдааг залруулж, 423.4 сая төгрөгийн зөрчилд 19 төлбөрийн акт тогтоож, 1,009.8 сая төгрөгийн зөрчилд 34 албан шаардлага, 4,585.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 105 зөвлөмж өглөө.

### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд авлагыг 2,450.0 сая төгрөгөөр, бараа материалыг 384.0 сая төгрөгөөр, өр төлбөрийг 1,024.0 сая төгрөгөөр тус тус дутуу нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд татан буулгасан МХС-ийн хаалтын тайлангаарх авлага, өр төлбөр нийт 10,836.3 сая төгрөгийг шилжүүлэн бүртгэхдээ үнэ төлбөргүй орлогоор илэрхийлсэн;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд дээрх хаалтын тайлангаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг 307.0 сая төгрөгөөр дутуу нэгтгэсэн байна.

### Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт

Өмнөх онуудад ашиглалтад орсон барилга, байгууламжийн техник хяналтын зардлын 79.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн 738.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

### Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Мал эмнэлгийн ерөнхий газар буюу төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгч, нийт 77.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1 алдааг залруулж, 77.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өглөө.

### Төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн 58 байгууллагаас 6 байгууллагад итгэл үзүүлж, 3 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, “Зөрчилгүй” 47, Малын удмын сангийн үндэсний төв, Говь-Алтай аймгийн Мал эмнэлгийн газарт “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 5,094.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3,594.6 сая төгрөгийн алдааг залруулж, 206.8 сая төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт тогтоож, 578.1 сая төгрөгийн зөрчилд 27 албан шаардлага, 714.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 88 зөвлөмж өглөө.

### Төрийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төрийн өмчит 2 аж ахуйн нэгж байгууллагаас “Зөрчилгүй” 1, Хөдөө, аж ахуйн биржийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 8,614.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 8,592.8 сая төгрөгийн алдааг залруулж, 2.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 3 зөрчилд албан шаардлага, 18.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 7 алдаа, зөрчилд зөвлөмж өглөө.

### Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 3 тусгай сангаас 1 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулан, “Зөрчилгүй” 1, Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 5,947.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,348.8 сая төгрөгийн алдааг залруулж, 134.6 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 427.9 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 3,036.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өглөө.

Харьяа тусгай сангуудад 134.6 сая төгрөгийн төлбөрийг барагдуулах 2 акт тогтоож, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 259.0 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

- ЖДҮХС Хөгжлийн банкны бондыг Үндэсний хөрөнгө оруулалтын банкаар дамжуулан зээлдүүлэн олгосон, тайлант онд төлбөл зохих 232.9 сая төгрөгийн зээл, зээлийн хүүг барагдуулаагүй, ТЭДС нь 26.1 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг төлүүлэлгүйгээр дэмжлэг олгосон зэрэг зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ЖДҮХС ажилтнуудад олгосон урамшууллаас нийт 5.7 сая төгрөгийн НДШ-ийг суутган тооцоогүй, ТЭДС улаан буудайн үр зээлээр худалдах, тариаланчдад олгосон дэмжлэгийн эргэн төлөлт 128.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүйд төлбөрийн акт тогтоосон байна.

### Төсөл, хөтөлбөрийн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 3 төсөл хөтөлбөрийн нэгжид “Зөрчилгүй” дүгнэлт өгч, нийт 3.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

## 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант онд харьяа тусгай сангуудтай холбоотой анхаарал татах дараах асуудлууд гарсан байна. Үүнд:

1. Хүнсний үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдлээс оны эцэст нөөцийн мах бэлтгэсэн аж ахуйн нэгж байгууллагын зээлийн хүүгийн хөнгөлөлтийг гэрээний дагуу зарцуулсан;
2. “Тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 87 дугаар тогтоолд сангуудын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтын талаар тусгасан асуудлууд:
  - Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Мал хамгаалах сан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санг нэгтгэх, хуримтлагдсан эх үүсвэр, өглөг, авлагыг шилжүүлэх, сангийн ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, урамшуулал, дэмжлэгийн механизмыг боловсронгуй болгох, сангуудад бүртгэлтэй хөрөнгийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр холбогдох хуулийн болон бусад шийдвэрийн төслийг боловсруулах;
  - Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Мал хамгаалах сангаас олгож байгаа урамшууллыг жил бүрийн улсын төсөвт тусган, санхүүжүүлэх арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн боловсронгуй болгож зохион байгуулах;
  - Санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлттэй зээл олгох үйл ажиллагаа явуулдаг сан, тусгай сан, төсөл, хөтөлбөрүүдийг Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаар дамжуулж, нэгдсэн удирдлага, хяналтад оруулах арга хэмжээ авч, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах;
3. “Мал хамгаалах сангийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 179 дүгээр тогтоолд сангийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтын талаар тусгасан асуудлууд:
  - Мал хамгаалах сангийн үйл ажиллагааны чиглэл, урамшуулал, санхүүгийн дэмжлэгийн механизмыг боловсронгуй болгох чиглэлээр дараах арга хэмжээг авч хуульд нийцүүлэн сангийн ажлын албыг татан буулгах;
  - Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан арга хэмжээ болон төсвийн урамшууллыг ХХААХҮЯ-аар дамжуулан хэрэгжүүлэх;
4. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр батлагдаж 2020 оны 1 дүгээр сарын 1-ээс дагаж мөрдөхөөр;
5. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх тухай 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар хууль хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс өмнө Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Мал хамгаалах сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгө, өглөг, авлагыг Хөдөө аж ахуйг дэмжих санд шилжүүлнэ;
6. “Хөдөө, аж ахуйг дэмжих сангийн ажлын алба байгуулах, орон тооны хязгаарыг батлах тухай” Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 16 дугаар тогтоолоор:
  - Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын алба байгуулж, орон тооны хязгаарыг 164 байхаар;
  - Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албаны дүрэм, зохион байгуулалтын бүтцийг орон тооны хязгаар, батлагдсан төсөвт багтаан баталж, сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах;
  - Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгө, өглөг, авлага болон Мал хамгаалах сангаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд шилжүүлсэн хөрөнгө, өглөг, авлагыг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу Хөдөө аж ахуйг дэмжих санд шилжүүлэхээр тус тус заасан байна.

Дээрх хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ТӨБЗГ-ын 2019 оны 280 дугаар тогтоол болон ХХААХҮС-ын холбогдох тушаалуудаар МХС-ийн 2019 оны жилийн эцсийн байдлаарх мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөрийг харьяа газруудад шилжүүлэн бүртгэж хаалтын тайланг гаргасан байна.

Харин дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар холбогдох хууль, журам, тушаал шийдвэрийн дагуу ТЭДС-г татан буулгаж, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албаны дүрэм, зохион байгуулалтын бүтцийг орон тооны хязгаар, батлагдсан төсөвт багтаан баталж ажилласан эсэхийг үргэлжлүүлэн авч үзнэ.

Мөн татан буугдсан тусгай сангуудын олон жил болсон, эзэн холбогдогчгүй болон төсөвт төвлөрүүлэх авлага, өр төлбөрийг барагдуулахад санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, дээд шатны харьяалах төрийн захиргааны төв байгууллагууд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд арга хэмжээ авч, шийдвэрлэхэд анхаарал хандуулахыг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын тайланд тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

Тусгай сангаар дамжуулан хэрэгжиж байгаа гадаадын зээлийг дотоодод дамжуулан зээлдүүлэх техникийн зээлийг хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаа, сангуудаас олгосон зээл, дэмжлэг, урамшууллын үр дүнд гүйцэтгэлийн аудит хийх шаардлагатай байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу 77 мэдээллийг хугацаанд нь, 53 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн 266.1 сая төгрөгийн 5 зөвлөмж өгснөөс 4 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа нийт зөвлөмжийн хэрэгжилт 90 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС, АОУС, журам, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Залруулагдаагүй 6,019.1 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 8,151.8 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул зөрчилгүй дүгнэлтийг өгч байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим чиглэгдсэн.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан кассын зарцуулаагүй үлдэгдлийг харилцах дансанд төвлөрүүлэх, төсвийн зарцуулалтад тавих шат шатны хяналтыг сайжруулах цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

#### **3.1 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Хөтөлбөр арга хэмжээний санхүүгийн тайлангаар оны эцэст 20.1 сая төгрөгийн кассын үлдэгдэлтэй байгаа нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 1 дүгээр хавсралтын 6.2-д "Төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээ(ЖМС) нь тухайн төсвийн байгууллагын жилийн батлагдсан төсвөөс (ЖБТ) хамааран дараах хэмжээтэй байна". Үүнд: ЖБТ 1,000,000,000 төгрөгөөс дээш -ЖМС 1,500,000- 3,000 000 төгрөг гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Төсвийг зориулалт бусаар зарцуулах, журмыг мөрдөхгүй байх

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Кассын зарцуулаагүй үлдэгдлийг харилцах дансанд төвлөрүүлж байх, Сангийн сайдын 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ыг мөрдөн ажиллах

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

#### **3.2 Хөрөнгө оруулалтын санхүүжилттэй холбоотой асуудал**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

Хэрэгжээгүй хөрөнгө оруулалтын 7 ажлын санхүүжилт 718.4 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ",

45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### **3.2.2 Эрсдэл:**

Төсөл, арга хэмжээг хэрэгжээгүй байх, хууль, дүрэм, журмууд хоорондоо зөрчилдөх, мөрдөж ажиллахгүй байх

### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэлээр санхүүжүүлж, тухай жилийн төсвийн хэрэгжилтийг ханган ажиллаж төсвийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, төсвийн зарцуулалтад тавих шат шатны хяналтыг сайжруулах

### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## **3.3 Харьяа газруудад илэрсэн алдаа, зөрчилтэй холбоотой асуудал**

### **3.3.1 Илрүүлэлт:**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 67 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс итгэл үзүүлсэн 6 байгууллага, 3 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан, 58 байгууллага аудитад хамрагдсан байна.

Аудитаар 54 санхүүгийн тайланд "Зөрчилгүй", 4 санхүүгийн тайланд "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 11,933.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 5,951.9 сая төгрөгийн 27 алдааг залруулж, 344.0 сая төгрөгийн зөрчилд 18 төлбөрийн акт тогтоож, 1,019.3 сая төгрөгийн зөрчилд 35 албан шаардлага, 4,618.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 103 зөвлөмж өглөө.

Төрийн аудитын тухай хулийн 28 дугаар зүйлийн 28.1-д ".....санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ"

### **3.3.2 Эрсдэл:**

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй, дээд шатны удирдлагын дотоод хяналт сул байх.

### **3.3.3 Өгсөн зөвлөмж:**

Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, авлага өр, төлбөрийг бууруулах, бүртгэл тайлагналыг сайжруулах, төсвийн ерөнхийлөн захирагч үр дүнг дүгнэн, Төрийн аудитын тухай хуулийн 28.1, 2-дахь заалтын дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллах.

### **3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



#### 4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	648,349,848.6	640,787,046.4
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	14,914,231.4	6,418,938.0
33	<b>АВЛАГА</b>	543,002,643.8	519,389,632.8
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	2,098,826.5	2,143,386.4
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	44,450,866.6	37,938,162.3
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	43,883,280.2	74,896,926.8
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	173,338,187.9	174,393,114.3
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	173,338,187.9	174,393,114.3
39200	Биет хөрөнгө	140,304,505.1	141,166,789.3
39300	Биет бус хөрөнгө	33,033,682.8	33,226,325.0
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	821,688,036.5	815,180,160.7
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	390,368,399.3	329,966,631.6
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	165,828,297.6	105,730,485.7
41200	Богино хугацаат зээлийн өглөг	432,669.2	13,753,172.1
41300	Өглөг	161,047,138.8	91,516,145.6
41400	Урьдчилж орсон орлого	4,348,489.5	461,168.0
42	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	224,540,101.8	224,236,145.8
42100	Урт хугацаат үнэт цаас	99,561,000.0	50,047,797.3
42200	Урт хугацаат зээл	124,979,101.8	174,188,348.5
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	431,319,637.2	485,213,529.1
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	431,319,637.2	485,213,529.1
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	128,277,051.6	127,824,157.6
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	13,706,959.2	12,473,118.2
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	32,010.0	32,010.0
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	253,763,047.8	310,035,199.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	35,540,568.6	34,849,044.2
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	821,688,036.5	815,180,160.7

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	256,105,639.4	252,254,718.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	58,056,496.0	58,611,118.4
120	Нийтлэг татварын бус орлого	57,426,600.4	58,611,118.4
122	Тусламжийн орлого	629,895.5	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	198,049,143.5	193,643,599.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	144,553,737.1	154,909,141.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	126,071,417.2	154,909,141.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	74,604,339.5	98,170,992.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,404,580.6	12,880,279.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,260,985.0	1,667,890.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,342,822.6	1,463,652.4
2104	Хангамж, бараа материалын зардал	2,061,494.1	2,270,391.9
2105	Нормативт зардал	14,277,627.5	18,910,027.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	404,694.8	1,157,485.3
2107	Томилолт, зочны зардал	859,335.3	808,232.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,163,222.3	37,976,296.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,829,577.3	21,036,736.4
211	ХҮҮ	828,878.6	-
212	ТАТААС	48,906,186.4	49,655,766.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,732,012.7	7,082,382.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,482,319.9	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	111,551,902.4	97,345,576.6
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,799,759.6	949,692.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	43,593,386.9	36,410,130.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	69,758,275.1	61,885,139.2

#### 4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	510,182,276.3	439,469,933.9
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	374,546,157.5	297,016,800.6
120	Нийтлэг татварын бус орлого	373,916,262.0	297,016,800.6
122	Тусламжийн орлого	629,895.5	-
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	135,636,118.8	142,453,133.2
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	427,960,149.2	374,662,882.1
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	427,960,149.2	374,662,882.1
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	344,816,762.0	278,087,206.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,787,396.2	14,405,900.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,970,263.5	1,972,993.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,746,552.4	1,910,212.3
2104	Хангамж, бараа материалын зардал	2,760,652.2	3,313,256.6
2105	Нормативт зардал	11,227,304.7	13,496,833.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	613,208.3	1,506,025.6
2107	Томилолт, зочны зардал	859,294.2	789,026.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	259,594,043.6	233,044,455.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,258,046.9	7,648,501.4
211	ХҮҮ	828,878.6	-
212	ТАТААС	75,066,820.6	72,689,616.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,247,688.0	23,886,059.3
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	82,222,127.1	64,807,051.7
IV	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	135,260.1	184,346.8
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	29,010,452.1	24,668,200.0
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	29,010,452.1	24,668,200.0
2200	Дотоод эх үүсвэрээр	29,010,452.1	24,668,200.0
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	-28,875,192.0	-24,483,853.2
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	-80,383,631.8	-48,818,492.0
14	Бусад эх үүсвэр	54.4	23.9
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	49,114,972.3	10,088,540.1
24	<b>ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР</b>	30,589,734.2	38,549,986.8
25	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	678,979.8	179,989.0
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	-27,036,696.7	-8,495,293.4
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	41,950,928.1	14,914,231.4
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,914,231.4	6,418,938.0

#### 4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	308,781,096.5	-	308,781,096.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-9,009,451.0	-	-9,009,451.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	299,771,645.6	-	299,771,645.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	31,283,628.9	-	31,283,628.9
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	30,549,708.5	-	30,549,708.5
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-43,620.9	-	-43,620.9
9	Тайлант үеийн үр дүн	69,758,275.1	-	69,758,275.1
10	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	431,319,637.2	-	431,319,637.2
11	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	431,319,637.2	-	431,319,637.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-7,712,612.8	-	-7,712,612.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	423,607,024.3	-	423,607,024.3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-78,750.9	-	-78,750.9
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-199,883.4	-	-199,883.4
19	Тайлант үеийн үр дүн	61,885,139.2	-	61,885,139.2
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	485,213,529.1	-	485,213,529.1

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	104,415,781.0	167,233,913.8	-62,818,132.8	160.2
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	133,840,520.6	121,727,955.6	12,112,565.0	91.0
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	75,906,882.1	71,503,370.0	4,403,512.1	94.2
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	11,328,020.4	11,129,271.2	198,749.2	98.2
210101	Үндсэн цалин	8,517,565.2	8,429,472.3	88,092.9	99.0
210102	Нэмэгдэл	2,051,360.1	1,959,739.7	91,620.4	95.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	714,398.1	701,322.5	13,075.6	98.2
210104	Урамшуулал	44,697.0	38,736.7	5,960.3	86.7
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	1,421,096.1	1,403,267.4	17,828.7	98.7
210201	Тэтгэврийн даатгал	965,814.9	969,973.1	-4,158.2	100.4
210202	Тэтгэмжийн даатгал	114,825.6	108,094.6	6,731.0	94.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	91,292.9	88,982.6	2,310.3	97.5
210204	Ажилгүйдлийн даатгал	22,651.1	21,670.0	981.1	95.7
210205	Эрүүл мэндийн даатгал	226,511.6	214,547.0	11,964.6	94.7
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	1,597,043.0	1,455,614.7	141,428.3	91.1
210301	Гэрэл, цахилгаан	616,331.8	538,505.3	77,826.5	87.4
210302	Түлш, халаалт	815,851.2	772,491.5	43,359.7	94.7
210303	Цэвэр, бохир ус	112,160.7	98,016.3	14,144.4	87.4
210304	Байрны түрээс	52,699.3	46,601.6	6,097.7	88.4
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,508,855.0	1,478,148.9	30,706.1	98.0
210401	Бичиг хэрэг	325,085.9	327,533.4	-2,447.5	100.8
210402	Тээвэр, шатахуун	761,072.6	761,013.4	59.2	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	263,609.8	235,228.7	28,381.1	89.2
210404	Ном, хэвлэл	845.0	914.9	-69.9	108.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,672.7	6,550.8	4,121.9	61.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	147,569.0	146,907.8	661.2	99.6
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	13,190,164.3	13,139,806.4	50,357.9	99.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,075,134.8	13,025,650.7	49,484.1	99.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	115,029.5	114,155.7	873.8	99.2
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,583,553.7	2,555,540.1	28,013.6	98.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,163,581.9	1,083,155.7	80,426.2	93.1
210602	Тавилга	29,760.0	128,203.2	-98,443.2	430.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,824.9	9,990.3	834.6	92.3
210604	Урсгал засвар	1,379,386.9	1,334,190.9	45,196.0	96.7
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	563,921.1	523,768.8	40,152.3	92.9
210701	Гадаад албан томилолт	-	-	0.0	
210702	Дотоод албан томилолт	563,921.1	523,768.8	40,152.3	92.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	41,962,466.7	38,131,847.2	3,830,619.5	90.9

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,651,355.9	37,851,749.4	3,799,606.5	90.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	21,631.1	16,365.1	5,266.0	75.7
210803	Даатгалын үйлчилгээ	63,845.4	57,830.2	6,015.2	90.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	22,221.9	17,249.7	4,972.2	77.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	7,079.5	4,258.3	2,821.2	60.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	172,921.4	166,034.2	6,887.2	96.0
210807	Газрын төлбөр	23,411.5	18,360.4	5,051.1	78.4
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,751,761.8</b>	<b>1,686,105.3</b>	<b>65,656.5</b>	<b>96.3</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,697,263.5	1,634,010.1	63,253.4	96.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	54,498.3	52,095.2	2,403.1	95.6
